



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэргэлэн хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОО-2020/14/СТА-ОНӨААТҮГ

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2020 он	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn Аудитор: Б.Одхүү Утас: 70584207 Цахим хаяг: Odkhuu@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НББ	Нягтлан бодох бүртгэл
ЗДТГ	Засаг даргын тамгын газар



Аудитын гэрчилгээ	3
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	10
4.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	10
4.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	10
4.3. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	11
4.4. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлтийн тайлан	11



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

Холо, 03.13 № 279

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Сэргэлэн хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Сэргэлэн хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон тодруулга тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Сэргэлэн хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110520194



Үүрэг, хариуцлага

Сэргэлэн хөгжил ОНӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандартуудтай нийцүүлэн түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Сэргэлэн хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Засаг дарга Н.Гүррагчаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Сэргэлэн хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэргэлэн хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 02-ноос 2020 оны 03 дугаар сарын 12-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Б.Одхүү хариуцаж хэрэгжүүлэв.

Сэргэлэн хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/38 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Сэргэлэн хөгжил ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Сумын иргэдийн эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөлийг хангах” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Сэргэлэн хөгжил ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Албан байгууллага айл өрхийн хог ачилт болон цэвэрлэгээг тогтмол хийх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Сэргэлэн хөгжил ОНӨААТҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорнод аймгийн Сэргэлэн хөгжил ОНӨААТҮГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд санхүүгийн программ хангамж ашиглаагүй байна.

Сэргэлэн хөгжил ОНӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Сэргэлэн хөгжил ОНӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 3 эрсдэлтэй асуудалд 3 горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 26,322.3 мянган төгрөгөөс тооцон 526.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 1,021.4 мянган төгрөгөөр тооцсон нь 2019 онд зардлын гүйцэтгэл өссөнтэй холбоотой болно.



2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Сэргэлэн хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 50,698.2 мянган төгрөгөөр буюу 32,5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан ашиг дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	448.7	215.7	273.0
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	6,360.5	6,360.5	0.0
Үндсэн хөрөнгө	273,179.5	273,179.5	0.0
Элэгдэл	-124,197.2	-174,895.4	50,698.2
Нийт хөрөнгө	155,831.6	104,860.3	-50,971.2
Өр төлбөр			
Хуримтлагдсан ашиг	155,831.6	104,860.3	-50,971.2
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл			0.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	155,831.6	104,860.3	-50,971.2

Авлага дансны үлдэгдэл өөрчлөгдөөгүй.

Бараа материалын дансны үлдэгдэл өөрчлөгдөөгүй байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй байгаа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өөрчлөгдөөгүй.

Биет бус хөрөнгийн үлдэгдэл өөрчлөгдөөгүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл өөрчлөгдөөгүй байна.

Хуримтлагдсан ашиг дансны үлдэгдэл 104,860.3 мянган төгрөг болж 50,971.2 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал өссөнтэй холбоотой байна.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Тайлант онд Сэргэлэн хөгжил ОНӨААТҮГ нь нийт 100.0 мянган төгрөгийн орлоготой ажиллажээ. Үүнээс түрээсийн орлогоор 100,0 мянган төгрөгийг төвлөрүүлж, машины татвар даатгал, үйлчилгээний хураамжид 363.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж нийт 3 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар санхүүгийн тайланд 50,7 сая төгрөгийн залруулж хийж залруулагдаагүй алдаа зөрчил ирлээгүй болно.



2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Сумын Засаг дарга тус байгууллагын даргын ажлыг давхар гүйцэтгэж байгаа нь хуульд нийцэхгүй байгаа тул цаашид анхаарах.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Сэргэлэн хөгжил ОНӨААТҮГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага нь Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллээ бүрэн байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдаж зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Сэргэлэн хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Сэргэлэн хөгжил ОНӨААТҮГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>6 849 245,04</u>	<u>6 576 212,04</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	488 745,04	215 712,04
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	488 745,04	215 712,04
3121	Төгрөг	488 745,04	215 712,04
31213	Арилжааны банк дахь харилцах	488 745,04	215 712,04
35	БАРАА МАТЕРИАЛ	6 360 500,00	6 360 500,00
354	Хангамжийн материал	6 360 500,00	6 360 500,00
35420	Аж ахуйн материал	6 360 500,00	6 360 500,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>148 982 316,93</u>	<u>98 284 099,55</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	148 982 316,93	98 284 099,55
392	Биет хөрөнгө	148 982 316,93	98 284 099,55
39201	Барилга, байгууламж, орон сууц	6 827 490,00	6 827 490,00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(4 708 038,84)	(6 827 490,00)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	32 900 000,00	32 900 000,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(22 750 000,00)	(32 830 000,00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	233 452 043,00	233 452 043,00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(96 739 177,23)	(135 237 943,45)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>155 831 561,97</u>	<u>104 860 311,59</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>155 831 561,97</u>	<u>104 860 311,59</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	155 831 561,97	104 860 311,59
512	Хуримтлагдсан үр дүн	155 831 561,97	104 860 311,59
51210	Өмнөх үеийн үр дүн	182 153 884,29	155 831 561,97
51220	Тайлант үеийн үр дүн	(26 322 322,32)	(50 971 250,38)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>155 831 561,97</u>	<u>104 860 311,59</u>

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	0,00	100000,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0,00	100000,00
120	Нийтлэг татварын бус орлого	0,00	100000,00
120005	Түрээсийн орлого		100000,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	26322322,32	51071250,38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	26322322,32	51071250,38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26322322,32	51071250,38
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24000,00	373033,00
210813	Бусад зардал /ТӨҮГ/	24000,00	373033,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26298322,32	50698217,38
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26298322,32	50698217,38
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-26322322,32</u>	<u>-50971250,38</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-26322322,32</u>	<u>-50971250,38</u>



4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	0,00	100000,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0,00	100000,00
120	Нийтлэг татварын бус орлого	0,00	100000,00
120005	Түрээсийн орлого		100000,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	24000,00	373033,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	24000,00	373033,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	24000,00	373033,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	24000,00	373033,00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	24000,00	373033,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-24000,00	-273033,00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-24000,00	-273033,00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	512745,04	488745,04
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	488745,04	215712,04

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0,00	0,00	182 153 884,29	0,00	182 153 884,29
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0,00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0,00	0,00	182 153 884,29	0,00	182 153 884,29
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0,00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт		0,00			0,00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0,00
C07	Тайлант үеийн үр дүн			-26 322 322,32		-26 322 322,32
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0,00	0,00	155 831 561,97	0,00	155 831 561,97
D01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0,00	0,00	155 831 561,97	0,00	155 831 561,97
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0,00	0,00	0,00	0,00	0,00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0,00	0,00	155 831 561,97	0,00	155 831 561,97
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0,00	0,00	0,00	0,00	0,00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0,00	0,00	0,00	0,00	0,00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0,00	0,00	0,00	0,00	0,00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0,00	0,00	0,00	0,00	0,00
D08	Тайлант үеийн үр дүн	0,00	0,00	(50 971 250,38)	0,00	-50 971 250,38
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0,00	0,00	104 860 311,59	0,00	104 860 311,59

